

МОНГОЛ УЛСЫН ЭРДМИЙН ИХ СУРГУУЛЬ



Чимэдийн Мандалсайхан

**НАСТНЫ СУВИЛАХУЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ**

Боловсрол судлалын доктор (Ph.D)-ын зэрэг
горилсон нэг сэдэвт бүтээл

Мэргэжлийн индекс: F01110101

Улаанбаатар хот
2019 он

МОНГОЛ УЛСЫН ЭРДМИЙН ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй

Чимэдийн Мандалсайхан

НАСТНЫ СУВИЛАХУЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Боловсрол судлалын доктор (Ph.D)-ын зэрэг
горилсон нэг сэдэвт бүтээл

Мэргэжлийн индекс: F01110101

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:
Доктор (Sc.D), профессор О.Пүрэв
Доктор (Ph.D) А. Булгаа

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ОНОЛ, АРГАЗҮЙН СУДАЛГАА	
1.1. Сургалтын хөтөлбөрийн орчин үеийн онол, аргазүйн үндэс.....	10
1.2. Настны сувилахуйн тухай ойлголт.....	36
1.3. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй олон улсын туршлага.....	58
ХОЁРДУГААР БҮЛЭГ. НАСТНЫ СУВИЛАХУЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА	
2.1. Монгол улсад хэрэгжиж буй настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн харьцуулсан судалгаа.....	75
2.1.1. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн шинжилгээ.....	85
2.1.2. Геронтологийн үндэсний төвийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн шинжилгээ.....	88
2.1.3. АШУҮИС-ийн Говь-Алтай Анагаах Ухааны сургуулийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн шинжилгээ.....	91
2.2. Баруун бүсийн ахмад настны өвчлөл, гэмтэл бэртэлд өртөх эрсдэлийн судалгаа.....	95
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮР ДҮНД СУУРИЛСАН НАСТНЫ СУВИЛАХУЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ	
3.1. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал.....	108
3.2. Үр дүнд суурилсан настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулсан нь.....	112
3.3. Үр дүнд суурилсан настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх санал, зөвлөмж.....	118
ДҮГНЭЛТ	122
НОМЗҮЙ	126
ХАВСРАЛТ	133

ТОВЧИЛСОН ҮГ

1. АШУҮИС - Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль
2. АУ - Анагаах ухаан
3. АУБ - Анагаах ухааны боловсрол
4. АНУ - Америкийн Нэгдсэн Улс
5. БСШУ - Боловсрол Соёл Шинжлэх Ухаан
6. БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс
7. БНСУ - Бүгд Найрамдах Солонгос Улс
8. ГТХАН - Герман Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
9. ДЭМБ - Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
10. ДАУБХ - Дэлхийн Анагаах Ухааны Боловсролын Холбоо
11. ЕБС - Ерөнхий Боловсролын Сургууль
12. ЗХУ - Зөвлөлт Холбоот Улс
13. МСС - Мэдээлэл сургалт сурталчилгаа
14. НҮБ - Нэгдсэн Үндэсний Байгууллага
15. НҮЭМ - Нөхөн үржихүйн эрүүл мэнд
16. ТББ - Төрийн бус байгууллага
17. ХАХОУБХ - Хүн Ам Хөгжил Олон Улсын Бага Хурал
18. ЭМЯ - Эрүүл Мэндийн Яам
19. ЭМД - Эрүүл мэндийг дэмжих
20. СХДЭМН - Сонгино Хайрхан Дүүрэг Эрүүл Мэндийн Нэгдэл
21. СХНЭМТ - Сонгино Хайрхан Нэгдэл Эрүүл Мэндийн Төв
22. ГССҮТ - Гэмтэл Согог Сэргээх Үндэсний Төв
23. УКТЭ - Улсын Клиникийн Төв Эмнэлэг
24. СҮА – Сувилгааны үйл ажиллагаа
25. АУС - Анагаах Ухааны Сургууль
26. ХЧА - Хөдөлмөрийн чадвар алдалт
27. САТ - Сэхээн амьдруулах тасаг
28. УСТ - Улсын Стандарт Төв
29. МУИС - Монгол Улсын Их Сургууль

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1.1. Сургалтын уламжлалт хөтөлбөр болон үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн ялгаа
- Хүснэгт 1.2. Сургалтын төлөвлөгөөний цар хүрээ
- Хүснэгт 1.3. Сургалтын хөтөлбөрийн талаар гадаадын эрдэмтэн, судлаачдын орчин үеийн үзэл баримтлал
- Хүснэгт 1.4. Настны эрхтэн системд гарах өөрчлөлтүүд
- Хүснэгт 1.5. Европын холбооны гишүүн орнуудын настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн агуулга
- Хүснэгт 1.6. Өндөр хөгжилтэй орнууд дахь насжилтын үзүүлэлт
- Хүснэгт 1.7. Японы настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр
- Хүснэгт 1.8. Японы практик сургалтаар туршлагажуулж сургах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр
- Хүснэгт 1.9. Японы настны асрамжийн газарт явуулах сургалтын хөтөлбөр
- Хүснэгт 1.10. Японы халамжийн чиглэлийн ахлах сургуулийн хөтөлбөр
- Хүснэгт 2.1. Настны сувилахуйн сургалтын харьцуулалт
- Хүснэгт 2.2. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн нийт цагийн оноолт
- Хүснэгт 2.3. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн агуулгын харьцуулалт
- Хүснэгт 2.4. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн аргазүйн харьцуулалт
- Хүснэгт 2.5. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн үнэлгээний стандарт
- Хүснэгт 2.6. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн төгсөлтийн үнэлгээ
- Хүснэгт 2.7. Европ болон Азийн улс орнуудад хэрэгжиж буй настны сувилахуйн хөтөлбөрүүдийг Монгол улс дахь настны

- сувилахуйн мэргэшүүлэх хөтөлбөрүүдтэй харьцуулахад
- Хүснэгт 2.8. Настны сувилахуйн сургалтын харьцуулалт
- Хүснэгт 2.9. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн семинарын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө
- Хүснэгт 2.10. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн дадлагын хичээлд нэмэлтээр тусгагдсан сэдвүүд
- Хүснэгт 2.11. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн гардан хийх үйлдлийн жагсаалт
- Хүснэгт 2.12. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн бие даалтын хэлбэр
- Хүснэгт 2.13. Геронтологийн үндэсний төвийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн агуулга
- Хүснэгт 2.14. АШУҮИС-ийн Говь-Алтай АУ-ны сургуулийн мэргэшүүлэх сургалтын лекцийн хичээлийн агуулга
- Хүснэгт 2.15. АШУҮИС-ийн Говь-Алтай АУ-ны сургуулийн мэргэшүүлэх хичээлийн семинарын хичээлийн агуулга
- Хүснэгт 2.16. АШУҮИС-ийн Говь-Алтай АУ-ны сургуулийн мэргэшүүлэх сургалтын дадлагын хичээлийн агуулга
- Хүснэгт 2.17. АШУҮИС-ийн Говь-Алтай АУС-ийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн бие даалтын хэлбэр
- Хүснэгт 2.18. Настны үндсэн мэдээллийн үр дүн I
- Хүснэгт 2.19. Настны үндсэн мэдээллийн үр дүн II
- Хүснэгт 2.20. Насны бүлэг

Хүснэгт 2.21. Нас, жин, өндөр, халдварт бус өвчнөөр өвчлөх эрсдэл,
кальцийн дундаж үзүүлэлт

Хүснэгт 2.22. Морсын үнэлгээ

Хүснэгт 2.23. Кальцийн үзүүлэлт, хамрагдсан 2 бүлэг

Хүснэгт 2.24. Жин, кальци, эрсдэлийн дундаж үзүүлэлт

Хүснэгт 3.1. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн
цагийн агуулга

Хүснэгт 3.2. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын сайжруулсан
хувилбар хөтөлбөр

Хүснэгт 3.3. Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн ялгаатай тал

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1.1. Суралцахуйн үр дүн
- Зураг 1.2. Үр дүнд суурилсан загваруудын харьцуулалт
- Зураг 1.3. Сургалтын зорилгын таксоном
- Зураг 1.4. Танин мэдэхүйн үйл ажиллагааны 6-н түвшин
- Зураг 1.5. Хандлага мэдрэмжийн 5 түвшин
- Зураг 1.6. Үйл хөдлөлийн 6 түвшин
- Зураг 1.7. Сургалтын хөтөлбөрийн загварын дүрслэл

- Зураг 1.8. Хөтөлбөр боловсруулах зургаан алхам
- Зураг 1.9. Мэдлэг бүтээх Блүүмийн ангилалзүй

- Зураг 1.10. Үр дүнтэй сургах FAIR зарчим

- Зураг 1.11. Миллерийн гурвалжин

- Зураг 1.12. Киркпатрикийн үнэлгээний загвар

- Зураг 1.13. Анагаахын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах үе шатууд
- Зураг 1.14. Сургалтын хөтөлбөрийг боловсролын агуулга болох үүднээс тайлбарласан байдал

- Зураг 2.1. Сувилахуйн үйл ажиллагаа
- Зураг 2.2. Настанд зөвлөгөө өгсөн чиглэл
- Зураг 2.3. Настнуудын хараа, сонсголын байдал
- Зураг 2.4. Настны ээлтэй амьдрах орчин
- Зураг 2.5. Настнуудын тэнцвэр алдалт, сэтгэлзүй
- Зураг 2.6. Настнуудын бэртэл гэмтэл I
- Зураг 2.7. Настнуудын бэртэл гэмтэл II
- Зураг 2.8. Настнуудын бэртэл гэмтэл III
- Зураг 2.9. Кальцийн үзүүлэлт насны хамаарал
- Зураг 2.10. Морсын үнэлгээ насны харьцуулалт

- Зураг 2.11. Ясны сийрэгжилт Морсын үнэлгээний харьцуулалт
- Зураг 2.12. Настнуудын кальцийн үзүүлэлт
- Зураг 2.13. Кальцийн үзүүлэлт хүйсийн хамаарал
- Зураг 2.14. Настны бие даах чадвар, өдөр тутмын үйл ажиллагааны үнэлгээ
- Схем 1.1. Сургалтын хөтөлбөр
- Схем 1.2. Сургалтын хөтөлбөрийн бүтэц
- Схем 1.3. Хөтөлбөр боловсруулах зарчим
- Схем 1.4. Х. Табогийн дэвшүүлсэн сургалтын хөтөлбөрийн загвар
- Схем 1.5. Р. В. Тайлерын дэвшүүлсэн сургалтын хөтөлбөрийн загвар
- Схем 1.6. Сургалтын хөтөлбөрийн хөгжлийн үйл явц
- Схем 1.7. Үр дүнд суурилсан сургалтын загвар

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл

Дэлхий дахинд болон Монгол улсад хүн амын насжилт эрчимжиж, нийт хүн амд эзлэх настны тоо жил ирэх тутам өсөн нэмэгдсээр байгаа өнөө үед хөдөлмөрийн зах зээл дээр энэ чиглэлийн хүний нөөцийн эрэлт өссөөр, настанд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх нь сувилахуйн салбарт чухал байр суурийг эзэлж байна.

Настны сувилахуйг хөгжүүлэхэд чадварлаг сувилахуйн мэргэжилтнүүд шаардлагатай төдийгүй тэднийг чадвахжуулах нь сувилахуйн боловсрол, судалгаа шинжилгээ, практик үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм. Настны сувилахуйн боловсролыг сайжруулахын тулд олон мэргэжилтнийг энэ чиглэлээр сургах нь анагаахын болон сувилахуйн сургуулиудийн авч үзэж шийдвэрлэх ёстой тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Настны амьдралын чанарыг сайжруулахад настны сувилахуйн мэргэжилтэн онцгой үүрэг гүйцэтгэдэг. Настай хүмүүст нэг бус хэд хэдэн архаг хууч эмгэг байхын зэрэгцээ нас дагаж гарах эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны өөрчлөлт, сэтгэц, танин мэдэхүйн бууралт, нийгмээс тусгаарлагдах, ганцаардал зэрэг өөрчлөлтүүд гардаг тул сургалтаар дамжуулан настанд бие сэтгэл, нийгмийн талаас нь цогц үнэлгээг хийснээр настны эрүүл мэндийн хэрэгцээг тодорхойлж, цаашид настан бүрт тохирсон сувилахуйн тусламж үйлчилгээг практикт хэрэглэснээр, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээтэй дүйцэхүйц өндөр түвшний асаргааны технологи, настны сэтгэлзүйг дэмжих, эмнэлэг болон гэрийн нөхцөлд асаргаа сувилгааг тодорхой дэс дараалалтай, хоорондоо уялдаа холбоо бүхий тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаанд суралцах шаардлага зайлшгүй хэрэгтэй байна.

Анагаахын боловсрол олгодог сургуулиуд Монгол улсын шинэчлэлийн засгийн газрын мөрийн хөтөлбөр, эрүүл чийрэг Монгол хүн үндэсний хөтөлбөр, эрүүл мэндийн салбарын суурь шинэчлэлийн хүрээний үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол улсын засгийн газрын 2009 оны 5-р сарын 27-ны өдрийн 156 тоот тогтоолоор батлагдсан Монгол хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги, 2013 оны 12-р сарын 14-ний өдрийн 416 тоот тогтоолоор батлагдсан

эрүүл насжилт, настны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, эрүүл мэндийн сайдын 2012 оны 1-р сарын 3-ны 1 тоот тушаалаар батлагдсан настны сувилахуйн удирдамж, 2014 оны 491/472 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улам чанаржуулах, үр нөлөө уялдаа холбоог сайжруулах, эмч сувилагч нарын мэдлэг чадварыг байнга дээшлүүлж тэднийг сурч боловсрох боломжоор хангахыг зорин ажиллаж байна. Монгол улсын хэмжээнд настны сувилахуйн чиглэлээр мэргэшсэн сувилагч дутагдалтай, тухайлбал баруун бүсийн хэмжээнд нийтдээ 14 сувилагч л бэлтгэгдсэн байна.

Настанд цогц байдлаар тусламж үйлчилгээ үзүүлэх сувилагч мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулах нь тэднийг бэлтгэж байгаа сургуулиудын хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөртэй салшгүй холбоотой юм. Настны сувилахуйн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоход нэн тэргүүнд сургалтын хөтөлбөрийг судалж, нийгэм болон суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Судалгааны ажлын зорилго

Энэхүү зорилго нь суралцагчдын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, үр дүнд суурилсан настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоход чиглэсэн болно.

Судалгааны ажлын зорилт

Судалгааны ажлын зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөрийн онол, аргазүй, орчин үеийн үзэл баримтлалыг судлах,
2. Гадаадын улс орны настны сувилахуйн мэргэшүүлэх сургалт, хөтөлбөрүүдийг шинжлэх,
3. Монгол улсад хэрэгжиж буй настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг судлах,
4. Баруун бүсийн настны өвчлөлийг судалж, эрэлт хэрэгцээнд нийцсэн, үр дүнд суурилсан, настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн хувилбарыг боловсруулан, санал, зөвлөмж гаргах.

Судалгааны ажлын материал

Энэхүү судалгааны ажилд:

- Гадаадын эрдэмтэн судлаачид Уильям Спади., Р. М. Харден (Harden R. M, 1986), А. С. Орнстейн., Ф. П. Ханкинс, (Ornstein A. C., Hunkins F. P, 1993), Ж. Грант (Grant J, 2010), С. Колертон., Р. Жордан., Ж. Дент., Ф. П. Харден (Cholerton S., Jordan R., Dent J., Harden R, 2009), Боббит Н., Франклин (Bobbit., John Franklin, 2009), Харолд. Рагг (Harold Rugg, 1947), Хилда. Табо (Hilda Tabo, 1962), Ж. Ричард (Richard J. C, 2001) Р. В. Тайлер (Tyler R.W, 1949), А. Грийн (Green A, 1999), С. Р. Колес., Ж. Г. Грант (Coles C. R., Grant J. G, 1985), Б.С. Блүүм (Bloom B.S.1956) Д. Е. Керн., П. А. Томас., М. Т. Хагес (Kern D. E., Thomas P. A., Hughes M. T, 2010) зэрэг эрдэмтэдийн дэвшүүлсэн сургалтын хөтөлбөрийн орчин үеийн онол, үзэл баримтлал, практик ажлуудаас;
- Монгол эрдэмтэн судлаачдаас Наранчимэг С. (2002), Сүмбэрзул Н, (2003), Амарсайхан Д. (2003), Авирмэд Л, (2007) Алтангэрэл О, (2008), Отгонбаяр Д, (2010), Оюунцэцэг Н, (2011), Оюунсүрэн Э, (2012), Пүрэв.О (2013), Булгаа А, (2013), Энхбаатар Ц, (2014) Уранчимэг Н, (2014), Баясгаланмөнх Б, (2016), зэрэг эрдэмтэн судлаачдын сургалтын хөтөлбөрийн талаар судалсан ажлуудаас;
- Настнуудад үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (2008), настны эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ (2009), мянганы сорилын сангийн эрүүл мэндийн төсөл (2011), насжилтын талаар үндэсний стратеги (2014), боловсрол шинжлэх ухааны яамны А\174 тоот тушаал (2014), гэмтэл согог үндэсний төвийн мэдээ тайлан, (2017) ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль (2006), Монгол улсад хэрэгжиж буй настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр (2017), Европ, Азийн орнуудад хэрэгжиж байгаа настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр;
- Баруун бүсийн аймгийн төлөөлөл болох Говь-Алтай, Завхан, Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудын нийт 875 настныг судалгаандаа хамруулан, 400 настанд настны талаарх үндсэн мэдээллийн дагуу бодит үзлэг хийж, ясны

сийрэгжилтийг Tanita (АНУ-ын патенттай, ISO-9001 сертификатаар баталгаажсан, BC-533) багажаар хэмжиж, явганаас унаж бэртэх эрсдэлийг үнэлэх Морсын үнэлгээ, бие даах чадварыг үнэлэх Катзын үнэлгээ, өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааг үнэлэх Лавтоны үнэлгээний хуудас зэрэг материалуудыг практик хэрэглэгдэхүүн болгон ашиглав.

Судалгааны ажлын таамаглал

Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгосноороо сургалтын чанар сайжрах боломж бүрдэнэ.

Судалгааны ажлын объект

1. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр,
Геронтологийн үндэсний төвийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр,
АШУҮИС-ийн Говь-Алтай Анагаах Ухааны Сургуулийн настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр,
Европ, Азийн улс орнуудын настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр,
2. Баруун бүсийн төлөөлөл болох 875 ахмад настан

Судалгааны ажлын судлагдахуун

Геронтологийн үндэсний төв, АШУҮИС, Говь-Алтайн Анагаах Ухааны сургуулиудад хэрэгжиж буй настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүд болон Европ, Азийн улс орнуудын настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн бүтэц, агуулга, хамаарал.

Судалгааны ажлын арга

1. Танин мэдэхүйн ерөнхий аргуудаас ном зохиол судлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, загварчлах, харьцуулах; боловсрол судлалын аргуудаас баримт бичгийн шинжилгээ, контент анализ, ажиглалт, ярилцлагын арга, анагаах ухааны судалгааны аргуудаас; дескриптив судалгааны арга, тохиолдол хяналтын аргуудыг ашигласан болно.
2. Судалгааны үр дүнг SPSS-22.0 программ ашиглан боловсруулалт хийж, Т тестийн аргаар тоон хувьсуурын дундаж утгын ялгаатай байдлыг; чанарын

үзүүлэлтийн ялгааг χ^2 аргаар тус тус үзэж, P утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистик үнэн магадтай гэж үзэн хамаарлыг тооцож, параметрийн болон параметрийн бус корреляцийн шинжилгээ хийж тооцсон болно.

Судалгааны ажлын шинэлэг тал

Сургалтын хөтөлбөрийн орчин үеийн онол, аргазүйг судлан баруун бүсийн настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн, үр дүнд суурилсан настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн сайжруулсан хувилбарыг настны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын хэв маягийг өөрчлөх, наслалтыг уртасгахтай холбон тодорхойлсонд оршино.

Судалгааны ажлын практик ач холбогдол

1. Үр дүнд суурилсан настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн сайжруулсан хувилбар нь сувилахуйн салбарын сургалтын практикт хэрэглэгдэхүүн болох боломжтой.
2. Мэргэшүүлэх сургалтын чанарт ахиц гарах боломж нэмэгдэж, мэргэшсэн сувилагч нарыг бэлтгэн гаргаснаар настнуудад зориулсан асаргаа сувилгааны чанар сайжрах, цаашилбал, тэдний эрүүл мэндийн боловсролыг ахиулах, амьдралын хэв маяг, чанарыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

Судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал

1. Судалгааны үр дүнг Монгол Улсын Эрдмийн Их Сургуулийн боловсрол судлалын профессорын багийн их семинараар 2017, 2018 онд 3 удаа, өргөтгөсөн семинараар 1 удаа тус тус хэлэлцүүлсэн болно. Түүнчлэн АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн эрдэмтдийн зөвлөлийн 2015, 2016, 2017 оны хурлаар 3 удаа, судалгааны ажлын ёсзүйн дүгнэлтийг 2017 оны 3-р сарын 24-ны ёсзүйн хорооны хурлаар АШУҮИС-ийн био анагаахын судалгааны ёсзүйн дүрмийн шаардлагын дагуу материалыг бүрдүүлэн оролцогчдоос зөвшөөрлийг авсан болно.
2. Судалгааны ажлын сэдвийн дагуу олон улсын болон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд 10 удаа илтгэл тавин хэлэлцүүлж, эрдэм

шинжилгээний өгүүлэл зургаа, ном хоёр, гарын авлага, зөвлөмж, хөтөлбөр стандарт 10 гаруйг боловсруулан гаргасан болно. Үүнд:

1. Мандалсайхан Ч. Говь-Алтай аймгийн ахмад настны явганаас унаж бэртэх эрсдэлийг судалсан нь. // Эрдэм шинжилгээний бага хурал Есөнбулаг., 2015.
2. Мандалсайхан Ч. Настныг сувилгааны үйл ажиллагааны 5 шатлалаар үнэлсэн дүн. // Эрдэм шинжилгээний бага хурал. Есөнбулаг., 2015.
3. Мандалсайхан Ч. Ахмад настны бэртэж гэмтэх эрсдэлийн судалгаа // Есөнбулаг., 2016.
4. Мандалсайхан Ч. Настнуудын эрүүл мэндийн зарим үзүүлэлтийн үр дүн. // Эрдэм шинжилгээний бага хурал. Есөнбулаг., 2016.
5. Мандалсайхан Ч. Баруун аймгуудын ахмад настнуудын бэртэж гэмтэх эрсдэлийн зарим үр дүн, баруун аймгуудын ахмад настнуудын эрүүл мэндийн зарим үзүүлэлтийн үр дүн. // Эрдэм шинжилгээний бага хурал. Есөнбулаг., 2017.

Олон улсын хурал

1. Mandalsaikhan Ch., Odgerel L., Jargal J. Survey on the falling risk of elders. Present and future of Gerontology and Geriatrics. 2015.
2. Mandalsaikhan Ch., Tumendemberel N., Jargal J. Health issues among the elderly in western provinces of Mongolia. Medical advances and its trends. 2017.
3. Mandalsaikhan Ch., Tumendemberel N., Munkhjargal J. Research result of injury risk in seniors living in western territory of Mongolia. Medical advances and its trends. 2017.

Судалгааны ажлын сэдвийн хүрээнд нийтлүүлсэн бүтээл

1. Мандалсайхан Ч., Жаргал Ж. Ахмад настны унаж бэртэх эрсдэлийг судалсан нь. // Алхам урагш, эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, Судлаач 13. УБ., 2015.
2. Мандалсайхан Ч., Одгэрэл Л., Жаргал Ж. Настны эрүүл мэндийн байдлыг сувилгааны үйл ажиллагааны 5 шатлалаар үнэлсэн дүн. // Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, эрдмийн чуулган-57, Сувилахуй, Анагаах ухааны боловсрол судлал. УБ., 2015.

3. Мандалсайхан Ч., Одгэрэл Л., Жаргал Ж. Говь-Алтай аймгийн ахмад настны бэртэж гэмтэх эрсдэлийн судалгаа. // Нийгмийн эрүүл мэндийн Эрин сэтгүүл. УБ., 2015.
4. Мандалсайхан Ч., Түмэндэмбэрэл Н., Одонтуяа Ж., Одгэрэл Л. Ахмад настны бэртэж гэмтэх эрсдэлийн судалгаа. // Нийгмийн эрүүл мэндийн эрин сэтгүүл. УБ., 2016.
5. Мандалсайхан Ч. Настнуудын эрүүл мэндийн зарим үзүүлэлтүүдийн үр дүн. // МУЭИС-ийн магистрант доктрантын бүтээлийн эмхтгэл. УБ., 2016.
6. Мандалсайхан Ч., Түмэндэмбэрэл Н., Жаргал Ж. Баруун аймгуудын ахмад настнуудын бэртэж гэмтэх эрсдэлийн судалгаа. // Эрдэм шинжилгээний хураангуй бичиг. УБ., 2017.
7. Мандалсайхан Ч. Баруун бүсийн настнуудын эрүүл мэндийн үзүүлэлтийг судалсан нь. // Эрдэм шинжилгээний бага хурал. УБ., 2018.
8. Мандалсайхан Ч., Мөнхжаргал., О. Баян-Өлгий аймгийн ахмад настны бэртэж гэмтэх эрсдэлийн судалгаа. // Онош № 81. УБ., 2018.

Хамтран боловсруулсан сургалтын хөтөлбөр, удирдамж

1. Мандалсайхан Ч. Настны сувилахуйн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр. Есөнбулаг., 2016, 2017.
2. Мандалсайхан Ч. Настны сувилахуй. (сувилахуй, сувилагч, эх баригчийн ангийн оюутнуудад зориулсан) сургалтын хөтөлбөр. Есөнбулаг., 2016.
3. Мандалсайхан Ч., Оюунцэцэг Д., Түмэндэмбэрэл Н. Настанд үзүүлэх сувилахуйн тусламж. Багц цагийн сургалтын хөтөлбөр. Есөнбулаг., 2016, 2017.
4. Мандалсайхан Ч., Түмэндэмбэрэл Н. Настанд тохиолдох бэртэл гэмтэл, урьдчилан сэргийлэлт. Есөнбулаг., 2018.
5. Мандалсайхан Ч. Настны сувилахуйн удирдамж. Дадлагын удирдамж. Есөнбулаг., 2017.

Ном, сурах бичиг, гарын авлага

1. Мандалсайхан Ч. Судалгааны бүтээлийн эмхтгэл. УБ., 2016.
2. Мандалсайхан Ч. Сувилахуйн үндэс. УБ., 2017.

Судалгааны ажлын бүтэц

Судалгааны ажил нь удиртгал 3 бүлэг, 10 дэд бүлэг, дүгнэлт, ашигласан ном, хэвлэлийн жагсаалт, хавсралтаас бүрдсэн нийт 114 хуудастай. Диссертацид нэр томъёоны тайлбар, 28 зураг, 31 хүснэгт, 7 схем орсон болно.